

Англи хэлний  
хамгийн түгээмэл

# ХЭЛЦ ҮГС

idioms



амархан ном

АНГЛИ ХЭЛНИЙ  
ХАМГИЙН ТҮГЭЭМЭЛ

ХЭЛЦ ҮГС

idioms

Зохиогч: Д Арки Адриан-Валенс

# Агуулга

Өмнөтгөл 11

1. Хүмүүс 14

**Хүмүүсийн зан төлөв**

no rocket scientist · dark horse · party pooper

**Оюун ухаан ба гоо үзэсгэлэн**

turn heads · full of yourself · lost for words

**Үнэхээр гайхалтай**

the man in the street · larger than life · in the flesh

**Ихрүүд**

coach potato · dirty word · on the go · pain in the neck

2. Сэтгэл хөдлөл 23

**Бүх төрлийн сэтгэлийн хөдөлгөөн**

leaves me cold · on edge · (-ed) to death

**Инээмтгий хүмүүс**

in stitches · keep a straight face · burst out laughing

**Аз жаргал**

on top of the world · over the moon · on cloud nine

**Замаас үүдсэн уур хилэн**

see red · what got into him · lost it

**Шархалсан зүрх**

head over heels · break someone's heart · pick up the pieces

3. Нийгмийн харилцаа 34

**Үдэшлэг!**

push the boat out · small talk · hit it off

**Сайн найз**

be there for · see eye to eye · give and take

**Юу хэлдэг билээ?**

take a rain check · Finger crossed · On me

**Ажил дээр**

have a soft spot for · at each other's throats · breath of fresh air

#### 4. Хайр дурлал, болзоо

43

**Тэр надад талтай**

In your dreams · no way · play hard to get

**Хов жив**

going steady · he/she's history · get a life

**Үнэхээр сэтгэл татам**

drop-dead gorgeous · have a thing about · pop the question

**Анхны харцаар дурлах**

love at first sight · sweep someone off their feet · only have eyes for

**Болзоонд явсан нь**

pick up the tab · go Dutch · play it by ear

#### 5. Амьдрал

54

**Лоттигийн өдрийн тэмдэглэл**

in the same boat · Mr Right · get your act together

**Хэцүү байдалд орох**

hot water · in your shoes · off the hook

**Хөдөөгийн амьдрал**

life in the fast line · rat race · fish out of water

**Багийнхан амжилтандаа баярлацгаав**

keep your head above water · on a roll · put your feet up

#### 6. Харилцан яриа

63

**Киноны хэсгээс**

two-timing · put your foot in it · kick yourself

**Чи нууц хадгалж чадах уу?**

That would be telling · spill the beans · let the cat out of the bag

**Санал бодол**

You are telling me · You can say that again · hit the nail on the head

**Надад итгэл дээ!**

pull someone's leg · have someone on · pull the other one

**Чихээ түлэв**  
to say the least · get it straight · on Earth

## 7. Бодох, сурах 74

**Таамаглал**  
that'll be the day · on the cards · safe bet · touch and go  
**Ой тогтоолт**  
tie the knot · take some doing · slip your mind  
**Зөв ба буруу дуудлага**  
golden rule · get the hang of · just like that  
**Хөгжим сонсов**  
(can't) make head nor tail of · from scratch · have a go  
**Би нисэхээс айж байна**  
cut no ice · carry weight · take to heart

## 8. Үйл хөдлөл 85

**Нойрмог хулгайч**  
piece of cake · take your time · catch someone red handed  
**Адал явдалт киноны баатар**  
by the book · turn the tables · in the thick of  
**Спортын хэлц үг**  
score an own goal · touch base · the gloves are off  
**Жингээ хасах**  
do the trick · step on it · miss the boat  
**Халагдаж магадгүй шүү чи**  
soft touch · on the line · on top of

## 9. Бизнес, ажил хэрэг 96

**Бизнесийн амжилт**  
make a killing · make ends meet · get off the ground  
**Ажилд орох ярилцлага**  
off the cuff · think on your feet · make up your mind  
**В.І.С өрөнд оров**  
in the red · in the black · feel the pinch · on a shoestring  
**Шинэ ажил**  
find your feet · in at the deep end · sink or swim

**Чухал хүн**  
big fish · on board · mind's eye

10. Муу зүйлийн тухай 107

**Муу зүйл**  
below the belt · sit on the fence · mind your own business

**Сайн уу муу юу?**  
cut corners · around the clock · pull strings · turn a blind eye

**Хор**  
up in arms · thumbs down · get out of hand

**Ичмээр юм**  
break the ice · fall flat · split their sides

**Дурлалын паян**  
kiss-and-tell · call the shots · days are numbered

ТОВЪӨОГ 118



# *Өмнөтгөл*



## Хэлц үг буюу idiom гэж юу вэ?

Хэлц үг гэдэг нь хэрэглэгдэж байгаа үгсийн энгийн нийлбэр утгаар бол тун этгээд боловч жинхэнэдээ огт өөр утгатай байдаг нийлмэл үгсийг хэлнэ. Жишээ нь : **over the moon** (сарны дээр), **pulling someone's leg** (хэн нэгний хөлийг татах) гэх мэт. Гэтэл эдгээр хэлц үгсийн жинхэнэ утга нь :

**I'm over the moon** гэвэл *Би маш их баяртай / тааламжтай байна;*

**I'm just pulling your leg** гэвэл *Би тоглосон юм* гэсэн утгатай болно.

Хэлц үгийг харахад бүх үг нь ойлгомжтой (*over – дээр, moon – сар, pull – татах* гэх мэт) боловч яг зөв утгыг тааж олоход хэцүү байдаг. Иймд хэлц үгийг цээжилж тогтоохоос өөр замгүй.

## Хэлц үг юунд хэрэгтэй вэ?

Хэлц үг буюу idioms нь ярианы болон албан бус бичгийн англи хэлэнд түгээмэл байдаг. Иймд үүнийг мэддэг байх нь тун чухал бөгөөд зайлшгүй юм.

Ярианы англи хэлэнд, хүмүүсийн энгийн ярианаас эхлээд бизнесийн хурал зөвлөгөөнд хүртэл түгээмэл хэрэглэгдэнэ. Харин бичгийн англи хэлэнд бол ихэвчлэн сонин хэвлэлд тохиолдоно. Энэ нь мэдээ нийтлэлийнхээ гарчгийг сонирхолтой бөгөөд амьд өгөх гэсэн зохиогчдын хүслээс болдог билээ.

## Энэ номноос та юу сурах вэ?

Энэ номноос та **raining cats and dogs!** гэх мэт хуучирсан хэлцийг бус, харин хамгийн орчин үеийн англи хэлний өдөр тутам хэрэглэгддэг хэлц үгсийг сурах болно. Энд, хамгийн түгээмэл хэрэглэгдэх **140 гаруй** хэлцийг тайлбарласан байгаа. Ингэхдээ, хэлц бүрийн утгыг тодотгох богинохон эхүүдийг хавсаргасан нь түүний утгыг хялбархан таньж, хэрхэн яаж хэрэглэх вэ гэдгийг ойлгоход дөхөм болсон.

Номын төгсгөлийн **Товъёог**т энд орсон бүх хэлцийг латин цагаан толгойн дарааллаар байрлуулж, орчуулгыг тодруулах жишээний хамт хавсаргасан болно.

## Энэ номыг хэрхэн унших вэ?

Номын текстийг дуртай газраасаа уншаад уншаад явчиж болно.

Эсвэл,

- Хэлц үгийн жишээ эхийг уншиж, дотор нь тааралдах хэлц үгсийн утгыг ойлгохыг хичээнэ.
- Дараа нь, арынх нь хуудсанд байгаа орчуулгыг уншиж, өөрийн ойлгосноо шалгана.
- **Товъёог** хэсгээр дураараа сэлж, хэлц үгсийн утгыг мэдэж авна.

*1*

# *Хүмүүс*

## Хүмүүсийн зан төлөв



*He was **no rocket scientist** with computers.*

Does it matter if someone says you're **no rocket scientist**? Yes, it does! This phrase means not very intelligent.

What if a newspaper describes a politician as a **dark horse**? This means nobody knows much about him.

And a **party pooper**? This means a person who spoils enjoyable activities by refusing to join in. This idiom is also useful in apologies: “I’m sorry to be a party pooper, but I have to go home now.”

- **no rocket scientist**  
тийм ч ухаалаг бус хүн
- **dark horse**  
нууцлаг хүн
- **party pooper**  
үдэшлэг нураагч, үдэшлэгийг орхиж буй хүн


Хэн нэг нь чамайг чи бол **no rocket scientist** гэвэл ямар вэ? Мэдээж дургүйцэлгүй яах вэ! Энэ чинь чи тийм ч ухаантай биш гэсэн утгатай шүү дээ.

Сонинд нэгэн улс төрчийг **dark horse** хэмээн тодорхойлсон байвал энэ нь юу гэсэн үг вэ? Энэ бол түүний талаар хүмүүс сайн мэдэхгүй гэсэн үг.

Тэгвэл **party pooper** гэвэл? Энэ бол үдэшлэг цэнгээнд оролцохоос татгалзаж, нэг ёсондоо уг зүйлийг “нураасан” гэсэн утгатай. Үүнийг дараах байдлаар ашиглавал тохиромжтой : “Үдэшлэгийг орхиж байгаад уучлаарай, гэхдээ би гэр рүүгээ явах хэрэгтэй байна.”

*Тэр компьютерт  
тийм ч сайнгүй  
нэгэн байлаа.*

## Оюун ухаан ба гоо үзэсгэлэн



*Her car **turned** almost as many **heads** as she **did**.*

A Hollywood actress once met the British philosopher, Bertrand Russell. Whereas he was quite ugly, she **turned heads** wherever she went. She was rather **full of herself** and said to Russell, 'They say I'm the most beautiful woman in the world, and I hear you're the smartest man. Imagine if we had a child with your brains and my beauty.'  
Russel, who was never **lost for words**, replied, 'Imagine if it had my beauty and your brains.'

- **turn heads**  
анхаарал татах
- **full of yourself**  
өөртөө маш сэтгэл хангалуун байх
- **lost for words**  
хэлэх үггүй болох

Холивүүдийн жүжигчин эмэгтэй Британийн философич Бэрtrand Расселтай нэгэн удаа уулзжээ. Уг эмэгтэй бүхний **анхаарлыг татсан** нэгэн байсан бол харин нөгөөх нь тун ч царай муутай юмсанж. Ингээд өнөөх бүсгүй **өөртөө маш сэтгэл хангалуунаар** “Хүмүүс намайг дэлхийн хамгийн царайлаг бүсгүй гэцгээдэг юм. Харин би таныг хамгийн ухаантай хүн гэж сонссон. Хэрвээ бид [гэрлэж] чам шиг ухаантай, над шиг царайлаг хүүхэдтэй болвол ямар вэ?” гэхэд хэзээч **хэлэх үггүй байдаггүй** Рассел “Харин над шиг царайтай, чам шиг ухаантай төрчихвөл яах вэ?” хэмээн хариулсан гэдэг.

*Тэр хүүхний машин яг  
л өөр шиг нь бүхний  
анхаарлыг татаж  
байлаа.*

## Үнэхээр гайхалтай

*James Bond, the larger-than-life secret agent, was first played by Sean Connery.*



Say 'Sean Connery' to **the man in the street** and he'll probably say 'James Bond'. The famous British secret agent, 007, has been played by six actors in the last forty years, but Connery was the original and probably the best. He was **larger than life** both on the screen and **in the flesh**. Even in his 60s, he was chosen by the readers of an international women's magazine as the Worlds Most Attractive Man.



- **the man in the street**  
жирийн хүн, хэн нэгэн хүн
- **larger than life**  
үнэхээр гайхалтай
- **in the flesh**  
бодит хүн, бодит амьдралд

Хэрэв хэн нэгэн хүнд “Шон Коннер” гэж хэлбэл магадгүй тэр “Жеймс Бонд уу” гэх байх. Британийн алдартай нууц агент 007 –гийн дүрд сүүлийн дөчин жилийн хугацаанд зургаан жүжигчин тоглосон боловч Коннер бол хамгийн бодит, бараг хамгийн шилдэг нь байсан билээ. Тэр бол дэлгэцэн дээр ч **бодит амьдрал** дээрээ ч **үнэхээр гайхалтай** нэгэн. Бүр 60 гарсан хойно нь ч түүнийг олон улсын эмэгтэйчүүдийн сэтгүүлээс Дэлхийн Хамгийн Сэтгэл Татам Эрэгтэй -гээр нэрлэж байсан юм.

*Үнэхээр гайхалтай  
нууц агент Жэймс  
Бондын дүрд хамгийн  
анх Шон Коннер  
тогложээ.*




Some twins are identical, but my brother and I are definitely not. He's a **couch potato** who watches television all weekend and thinks exercise is a **dirty word**, whereas I always **on the go**, playing sport, socialising, working and so on. He says I'm a **pain in the neck** because I never stop doing things and making a noise while he's trying to watch the TV or sleep.

- **couch potato**  
залхуу хүн
- **dirty word**  
тааламжгүй зүйл, онцгүй зүйл
- **on the go**  
идэвхтэй
- **pain in the neck**  
уршиг, тээр

Зарим ихрүүд адилхан байдаг, харин миний ах бид хоёр бол үнэхээр өөр. Тэр бол бүх л амралтын өдрөөр телевиз үзэж өнгөрөөдөг, тун **залхуу нэгэн** бөгөөд дасгал бол **онцгүй зүйл** гэж үздэг, гэтэл би эсрэгээрээ, байнга **идэвхтэй** байж, спортоор хичээллэн, хүмүүстэй харилцаж, ажиллаж байдаг. Тэрээр намайг **тээртэй** гэж хэлдэг, учир нь би байнга ямар нэг юм хийж, чимээ гарган түүний телевиз үзэх эсвэл унтахад нь саад болдог гэсэн.

# *Сэтгэл хөдлөл*

## Бүх төрлийн сэтгэлийн хөдөлгөөн



*I'm sorry, Charles, but  
classical music just  
leaves me cold.*

Anger, happiness, love, hate, fear, boredom - whatever you feel, there's an idiom to put it into words. And if something doesn't excite you at all, you can say, it **leaves me cold**.

You can express moderate feelings such as I'm **on edge** (which is how you might feel before making a speech or having a tooth out), or strong feelings, such as, I was **bored to death**. I was **worried to death**. I was **scared to death**.

- **leaves me cold**  
надад ерөөсөө нөлөөлөхгүй байна
- **on edge**  
түгшүүртэй, айсан
- **(-ed) to death**  
хэтэрхий (-сэн), үхтлээ (-сэн)

Уурлах, баярлах, хайрлах, үзэх ядах, айх, уйтгарлах – алиныг нь ч мэдрсэн гэлээ та түүнийгээ үгээр илэрхийлбэл энэ чинь хэлц үг болно. Хэрэв ямар нэг зүйл үнэхээр сонирлыг чинь татахгүй байвал “энэ **надад ерөөсөө нөлөөлөхгүй байна**” гэж хэлж болно.

Мөн та дунд зэргийн мэдрэмжийг бол “Би **айж байна**” гэх мэтээр, илүү хүчтэй мэдрэмжээ бол “Би **үхтлээ уйдсан**”, “Би **үхтлээ санаа зовсон**”, “Би **үхтлээ айсан**” гэж илэрхийлж болно.

*Намайг уучлаарай  
Чарльз, гэхдээ  
сонгодог хөгжим  
надад ерөөсөө  
нөлөө үзүүлэхгүй  
байна.*

## Инээмтгий хүмүүс



*Everyone was in stitches.*

Somebody told a very funny joke at the office yesterday, and we were all **in stitches** for five minutes afterwards. Then the boss came in. He was in a bad mood and started to talk about a work problem. I couldn't forget the joke and I couldn't **keep a straight face**. The boss asked me what I was smiling at. When I told him, he just looked at me and said nothing. I thought he was going to throw me out. But then he burst out laughing!

- **in stitches**  
хөхрөх, их инээх
- **keep a straight face**  
мишээх ч үгүй инээх ч үгүй байх, гөлийх
- **burst out laughing**  
гэнэт чангаар инээх, түсхийтэл инээх

Өчигдөр ажил дээр хэн нэг нь үнэхээр инээдтэй онигоо ярьсаны дараа бид таван минут хэртэй **хөхөрцгөөсөн**. Тэгтэл дарга ороод ирсэн. Тэр нэлээд ууртай байсан бөгөөд ажилтай холбоотой бэрхшээлүүдээ ярьж гарлаа. Гэтэл би нөгөө онигоог мартаж чадахгүй байсан тул **инээхгүй байж** тэвчсэнгүй. Харин дарга юунд инээгээв гэж асуулаа. Би түүнд нөгөө онигоог ярьж өгтөл тэр над руу хараад юу ч хэлсэнгүй. Би ч намайг одоо халах байхдаа л гэж бодсон. Гэтэл тэр гэнэт **түсхийтэл инээв**.

*Бүгдээрээ  
хөхөрч байлаа.*



## Аз жаргал



*He was **over the moon**.*

It's a beautiful day, and I feel **on top of the world!**

He's just had some good news. He's got the job that he wanted, and he's **over the moon** about it.

Getting my first job as an actor was so exciting. I was **on cloud nine** for weeks afterwards.

- **on top of the world**  
аз жаргалтай байх
- **over the moon**  
үнэхээр сэтгэл хангалуун байх
- **on cloud nine**  
үнэхээр баяртай байх

Ямар сайхан өдөр вэ, би үнэхээр **аз жаргалтай байна!**

Тэр дөнгөж сая сайхан мэдээ авсан юм. Хүссэн ажилдаа орсон учраас түүндээ **үнэхээр сэтгэл хангалуун байна.**

Би анхны жүжигчний ажлаа аваад үнэхээр сайхан байсан. Бүтэн долоо хоногийн турш **үнэхээр баяртай байж** билээ.

*Тэр үнэхээр сэтгэл хангалуун байлаа.*

## Замаас үүдсэн уур хилэн



*What's got into  
him?*

### ROAD RAGE

As roads become busier, road rage is becoming more common. Ben Smith, 43, from London, was trying to park his car yesterday when another driver got in first. Smith **saw red**, jumped out, shouted at the other driver and started kicking the man's car, doing £800 worth of damage. Smith told police later, 'I don't know **what got into me**. I've never done anything like that before. I just **lost it**.'

- **see red**  
гэнэт маш ихээр уурлах
- **what got into him**  
тэр яагаад ийм аймар (ууртай, догшин) болчихов оо
- **lost it**  
ухаанаа алдах

Зам түгжрэхийн хэрээр түүнээс үүдсэн уур хилэн хаа сайгүй тохиолдож байна. Лондонгоос ирсэн 43 настай Бэн Смит өчигдөр машинаа тавихаар оролдож байтал өөр нэг жолооч өмнүүр нь дайраад тавьчихжээ. Смит **гэнэт маш ихээр уурлаж** машинаасаа үсэрч буугаад нөгөө жолооч руу хашгичан, машиныг нь өшгичиж эхлэсэн бөгөөд 800 фунтын хохирол учруулсан байна. Смит дараа нь цагдаад хэлэхдээ “Би **яагаад тэгж их уурласнаа** мэдэхгүй байна. Урьд нь ерөөсөө тэгж байгаагүй юм. Би бүр **ухаанаа алдчихсан** байсан” гэжээ.

*Тэр яагаад ийм  
аймар ууртай  
болчихов оо?*

## Шархалсан зүрх



*She **broke his heart** when she said goodbye.*

Almost as soon as he met her, he fell **head over heels** for her. They had six wonderful months together, and then she left. It **broke his heart**, and a year later he's only beginning to **pick up the pieces**.

- **head over heels**  
гэнэт, маш ихээр дурлах
- **break someone's heart**  
хэн нэгнийг тун ихээр гуниглуулах, зүрхийг нь шархлуулах
- **pick up the pieces**  
эвдэрсэн зүйлсээ эвлүүлэх, хэвэндээ орох

Бүсгүйтэй уулзав уу үгүй юу залуу түүнд **гэнэт, маш ихээр дурлажээ**. Тэд хамтдаа гайхалтай сайхан зургаан сарыг өнгөрөөсний дараа нөгөө эмэгтэй залууг орхин одов. Энэ нь залуугийн **зүрхийг шархлуулж**, бүтэн жилийн дараа л **хэвэндээ орж** эхлэв.

*Тэр эмэгтэй баяртай гэж хэлснээр залуугийн зүрх шархалсан юм.*

# *Нийгмийн харилцаа*

## Үдэшлэг!



*They really **pushed the boat out** for their daughter's wedding.*

January 6

I went to a big party last night. The hosts were celebrating something so they'd decided to **push the boat out** : there was a really good band, fantastic food and lots of drink. I chatted to a few people for the first hour – just the usual **small talk**. Then I met this great guy. We got talking and we really **hit it off**. I'm seeing him tomorrow!



- **push the boat out**  
маш ихийг зарцуулах
- **small talk**  
чухал биш зүйлийн талаар найрсаг яриа өрнүүлэх
- **hit it off**  
бие биендээ таалагдах

Нэгдүгээр сарын 6

Өнгөрсөн шөнө би томоохон үдэшлэгт очлоо. Үдэшлэгийн эзэд ямар нэгэн зүйлийг тэмдэглэж байсан бөгөөд тэд үүндээ **маш ихийг зарцуулсан** нь харваас илт байлаа. Тэнд тун сайн хамтлаг очсон байсан бөгөөд гайхалтай сайхан хоол, маш их уух зүйл байсан. Би эхлээд хэсэг хүмүүстэй **энгийн зүйлийн талаар дэмий яриа өрнүүлсэн**. Тэгээд дараа нь би энэ гайхалтай залуутай уулзсан. Бид ярилцсан, тэгээд **бие биендаа таалагдсан**. Би түүнтэй маргааш уулзна.

*Тэд охиныхоо хуриманд зориулж маш ихийг зарцуулсан.*



### A good friend

- is someone who will always **be there for** you when you need them.
- is someone who **sees eye to eye** with you on most things.
- is not perfect and not the same as you, but is good at **give and take**.

- **be there for**  
туслахад бэлэн байх
- **see eye to eye**  
зөвшөөрөх, санал нийлэх
- **give and take**  
буулт хийж хамтран ажиллах

Сайн найз гэдэг бол

- тусламж хэрэгтэй үед чинь **үргэлж бэлэн байдаг** юм.
- ихэнх зүйл дээр чамтай **санал нийлдэг** юм.
- бүх зүйлийг мэддэг байх, бүх зүйл дээр чамтай адилхан байх албагүй ч **буулт хийж хамтран ажиллаж** чаддаг юм.

*Сайн найзууд ч гэсэн  
бүх зүйл дээр санал  
нийлдэггүй.*

## Юу хэлдэг билээ?

*(The dinner's on me.)*



How can you say 'no' to an invitation for now but keep the invitation open for another time?

- Can I **take a rain check**?

What can you say if someone invites you to an event that is dependent on something else, such as good weather.

- (Let's keep our) **Fingers crossed**.

And if someone offers to pay for drinks or a meal, but *you* want to pay?

- This is **on me**.

- **take a rain check**  
урилгыг нээлттэй үлдээх
- **Fingers crossed**  
бүх зүйл сайхан болно гэж найдах, залбирах
- **On me**  
Би төлнө

Хүний хэлсэн урилгад яг одоо боломжгүй байгаа ч дараа боломжтой цагтаа хүлээж авъя гэсэн байдлаар татгалзсан хариу өгөхдөө юу гэж хэлэх вэ?

- Би энэ урилгаа нээлттэй үлдээж болох уу?

Хэрэв хэн нэгэн таныг уриад, харин таны явах эсэх ямар нэгэн зүйлээс, жишээлбэл цаг агаараас ч юмуу шалтгаалах бол юу гэж хэлэх вэ?

- Хоюулаа бүх зүйл **сайхан болоосой л гэж залбирья.**

Хэрэв хэн нэг нь таны авсан хоол, цайны үнийг төлөхийг санал болгоод, харин та өөрөө үүнийг төлмөөр байвал юу гэж хэлэх вэ?

- Үүнийг **би төлнө.**

*Оройн хоолны  
мөнгийг би төлнө.*

## Ажил дээр



*The new secretary  
is a **breath of fresh  
air.***

Old Mr Brown has been with the company for years. He's pretty useless, but he survives because the manager **has a soft spot for** him.

There are two bossy middle-aged women who are always **at each other's throats** about one thing or another.

There's a nice girl who started last week and is a **breath of fresh air.**

- **have a soft spot for**  
дуртай, санаа тавдаг
- **at each other's throats**  
маргалдах, үгээр давах
- **breath of fresh air**  
тааламжтай сайхан

Хөгшин Браун энэ компанид олон жил болсон. Тэр бараг хэрэггүй нэгэн боловч менежер түүнд **санаа тавьдаг**ийн ачаар одоо болтол эндээ байна. Энд мөн дунд эргэм насны хоёр эмэгтэй бий. Тэд үргэлж ямар нэг зүйл дээр **маргалдаж** байдаг. Харин өнгөрсөн долооногоос нэг сайхан бүсгүй манайд ажиллаж эхлэсэн нь үнэхээр **тааламжтай сайхан** байна.

*Шинэ нарийн бичиг ирсэн нь  
үнэхээр **тааламжтай сайхан**  
байна.*

# *Хайр дурлал, болзоо*



## Тэр надад талтай



TOM: I think she likes me.

SAM: **In your dreams!**

Tom: No, really, I'm sure she does.

SAM: **No way!** She never even looks at you.

TOM: Exactly! That means one of two things: either she's embarrassed because she fancies me, or she's **playing hard to get**.

SAM: Tom, there is a third possibility ...

- **In your dreams.**  
энэ бол бүтэшгүй мөрөөдөл
- **no way**  
ёстой үгүй, ёстой тийм биш
- **play hard to get**  
тоогоогүй юм шиг царайлах

Тоом: Тэр эмэгтэй надад талтай гэж би бодож байна.

Сээм: **Ёстой бүтэшгүй мөрөөдөл!**

Тоом: Үгүй ээ, үнэхээр тийм, би бүр итгэлтэй байна.

Сээм: **Ёстой тийм биш!** Тэр хэзээ ч чам руу харж байгаагүй шүү дээ.

Тоом: Тийм л дээ. Гэхдээ энэ нь нэг бол тэр надтай нүүр тулахаас ичсэнийх, үгүй бол тэр зүгээр л **тоогоогүй юм шиг царайлж** байгаа юм.

Сээм: Тоом, гэхдээ гуравдах хувилбар ч байж болно шүү дээ ...



*No, **he's history.**  
She's got a new  
boyfriend.*

ETHEL: Have you heard about Jane's boyfriend?

MAVIS: The one she's been **going steady** with for about six months?

ETHEL: No. **He's history.** She's got a new one.

MAVIS: That's fast!

ETHEL: Yes. And he's younger than her! Oh! Hello, Jane.

JANE: Haven't you got anything better to do than gossip about other people?  
**Get a life!**

- **going steady**  
энгийн харилцаатай
- **he/she's history**  
өнгөрсөн явдал, одоо бол чухал биш
- **get a life**  
арай дээр юм хийгээч (ээлдэг бус)

Ийтэл: Чи Жэйний найз залуугийн талаар сонсов уу?

Мэвис: Бараг зургаан сар орчим **энгийн харилцаатай** үерхэж байсан залуу юу?

Ийтэл: Үгүй ээ. Тэр бол **өнгөрсөн явдал**. Одоо тэр өөр шинэ найз залуутай болсон.

Мэвис: Ямар хурдан юм бэ!

Ийтэл: Тиймээ. Тэгээд нөгөөх нь өөрөөс нь дүү гэсэн. Өө, сайн уу Жэйн.

Жэйн: Та нарт бусдын тухай хов ярихаас өөр хийх юм алга уу? **Арай дээр юм хийгээч!**

*Үгүй ээ, тэр бол  
өнгөрсөн явдал. Одоо  
тэр шинэ найз залуутай  
болсон.*

## Үнэхээр сэтгэл татам



*Everyone thinks  
he's **drop-dead  
gorgeous**.*

Your letters  
Dear Romance Magazine

My boyfriend is **drop-dead gorgeous**, kind and sensitive, and we have a great relationship. He's also very tall. (**I have a thing about** tall men, so that's important to me too!) The problem is that I want to get married and have children, but he doesn't. I love him, but I know he's never going to **pop the question**. What should I do?

Julie (London)

- **drop-dead gorgeous**  
үнэхээр сэтгэл татам
- **have a thing about**  
үнэхээр их таалагдах
- **pop the question**  
“Чи надтай гэрлэх үү” гэж асуух

Таны захидал


Хүндэт Дурлалын сэтгүүлээ

Миний найз залуу бол **үнэхээр сэтгэл татам** нэгэн бөгөөд найрсаг, мэдрэмжтэй, бас бид хоорондоо маш сайхан харилцаатай. Тэр бас нэлээд өндөр. (Надад угаасаа өндөр эрчүүд **их таалагддаг**, тиймээс энэ бол надад маш чухал.) Гэхдээ нэг асуудал байгаа нь би хүнтэй гэрлэж, хүүхэдтэй болмоор байгаа юм, харин тэр бол үгүй. Би түүнийг хайрладаг, гэхдээ би түүний “Чи надтай гэрлэх үү” гэж хэзээ ч асуухгүйг мэдэж байна. Би юу хийвэл дээр вэ?

Жули (Лондон)

*Хүн болгон түүнийг  
үнэхээр сэтгэл  
татам гэж боддог.*

## Анхны харцаар дурлах



*It was **love at first sight**.*

There is a romantic story about the nineteenth-century revolutionary, Garibaldi. He was on his ship entering a port when he saw a beautiful woman standing on the shore. 'That is the woman I am going to marry,' he said. It was **love at first sight**.

The woman, when she met him, was **swept off her feet** by his good looks and personality. They were married within days and **only had eyes for** each other for the rest of their lives.

- **love at first sight**  
анхны харцаар дурлах
- **sweep someone off their feet**  
өөртөө дурлуулах
- **only have eyes for**  
үнэнч байх, үнэнчээр хайрлах

Арван есдүгээр зууны үеийн Гарибалдийн тухай нэгэн романтик түүх байдаг юм. Тэрээр өөрийн хөлөг онгоцоор боомт руу орж явахдаа нэгэн сайхан бүсгүй далайн эрэг дээр зогсож буйг харжээ. “Тэр эмэгтэйтэй би гэрлэнэ ээ.” гэж тэр хэлэв. Энэ бол **анхны харцаар дурласан** хэрэг байлаа.

Харин тэр эмэгтэй түүнтэй уулзаад өөрийн үзэмж төрх, байгаа байдлаараа түүнийг бүр ч **өөртөө дурлуулж** гэнэ. Тэд хэдхэн хоногийн дотор гэрлэж, харин дараа нь үлдсэн амьдралынхаа туршид бие биенээ **үнэнчээр хайрлажээ**.

【 Энэ бол **анхны харцаар дурласан хэрэг байлаа.** 】



## Болзоонд явсан нь



On a first date, who should pay for meals, drinks, tickets etc.? In the old days, the man would **pick up the tab**, but nowadays nobody is quite sure. Will the woman think he's a dinosaur if he pays? Or will she think he's mean if he doesn't? Will the man be grateful if the woman suggests they **go Dutch** or will he be insulted? There's no right answer. You just have to **play it by ear**. Be sensitive to your partner's feelings and you'll probably get it right.

- **pick up the tab**  
бүгдийг төлөх
- **go Dutch**  
өөр өөрсдөө төлөх, өөрсдийгөө даах
- **play it by ear**  
төлөвлөгөөгөө дагахгүй байх, баригдахгүй байх

Анхны болзоон дээрээ хоол, цай, тасалбарынхаа үнийг хэн нь төлбөл зохих вэ? Хуучны цагт бол эрэгтэй нь **бүгдийг төлдөг** байлаа, харин одоо бол энэ тун эргэлзээтэй болсон. Хэрэв эрэгтэй нь төлбөл хүүхэн түүнийг яасан хуучинсаг нөхөр вэ гэж бодох болов уу? Эсвэл төлөхгүй бол тааруухан амьтан байна гэж үзэх болов уу? Хэрэв эмэгтэй нь **өөрсдийгөө даая** гэж хэлбэл залуу баярлах болов уу, эсвэл доромжилж байна гэж үзэх үү? Энд яг тэр нь зөв гэх хэцүү юм. Харин та зүгээр л ямар нэг **төлөвлөгөөнд баригдалгүй** байх хэрэгтэй. Цуг яваа хүнээ сайн мэдэрч, тухайн үед аль нь дээр вэ гэдгийг сонгоорой.

*Чи өөр өөрсдийгөө даая гэж бодож байна уу?*

# *Амьдрал*

## Лоттигийн өдрийн тэмдэглэл



You'll find, **Mr Right** one day, dear.

January 6

I finished reading 'Bridget Jones's Diary' by Helen Fielding today. It's a very popular book, and I loved it because **Bridget and I are in the same boat**: we're both looking for **Mr Right** (without success) and trying to become famous in our careers (without success), and we're both sure that we'll get there as soon as we can lose weight, get fit and generally **get our act together**.

- **in the same boat**  
ижил нөхцөл байдалд байх
- **Mr Right**  
Төгс залуу
- **get your act together**  
өөрийгөө ямар нэг үйлд бэлдэх, бэлэн байх

Нэгдүгээр сарын 6

*Би Хелен Фийлдингийн “Брижит Жонсын өдрийн тэмдэглэл” номыг уншиж дуусгалаа. Энэ маш алдартай ном бөгөөд надад үнэхээр их таалагдсан. Учир нь Брижит бид хоёр **ижилхэн нөхцөл байдалд байгаа** юм билээ. Бид хоюулаа хэн нэгэн **төгс залууг** хайж байгаа (амжилт олоогүй), тус тусын салбартаа алдартай болохыг хичээж байгаа (бас л амжилтгүй), бас үүний тулд аль болох хурдан турах, мөн **ямар нэгэн зүйлд бэлэн байх** хэрэгтэй гэж үзэж байгаа.*

*Хонгор минь, нэг л өдөр  
чи өөрийн Төгс  
залуугаа олох болно.*

## Хэцүү байдалд орох



MIKE: Tom's in **hot water**.

JAKE: Why? What's he done?

MIKE: He borrowed a company car without permission and smashed it up.

JAKE: Is he OK?

MIKE: Yes, he's fine, but I wouldn't like to be **in his shoes** when the boss finds out.

JAKE: Oh, he'll make up a good story and get **off the hook**. He always does.

- **hot water**  
хэцүү байдалд орох
- **in your shoes**  
чиний нөхцөлд байх, чиний оронд байх
- **off the hook**  
бэрхшээлийг давах, асуудлаас гарах

Майк: Тоом **хэцүүхэн байдалд байна.**

Жэк: Яагаад, тэр юу хийчихээ вэ?

Майк: Тэр компанийн машиныг зөвшөөрөлгүй авч яваад эвдэж орхиж.

Жэк: Тэгээд өөрөө зүгээр үү?

Майк: Тиймээ, тэр зүгээр, гэхдээ дарга мэдчихвий гэхээс би **түүний оронд байхыг** хүсэхгүй л байна шүү.

Жэк: Өө, тэр ямар нэг сайхан түүх зохиогоод л **асуудлаас гарчихна** биз.

Байнга тэгдэг юм чинь.

## Хөдөөгийн амьдрал



*She was pleased to escape from the rat race.*

After five years of **life in the fast lane**, Janie decided to give up her well-paid city job and start a new life in a small country village. But although she was pleased to escape from the **rat race**, she felt like a **fish out of water** in the country. Now she's back in the city, wiser for her experience.



- **life in the fast lane**  
амьдралын хурдан, дарамттай хэмнэл
- **rat race**  
ажил хэргийн өрсөлдөөн
- **fish out of water**  
тааламжгүй, тухгүй нөхцөл, уснаас гаргасан загас шиг

Таван жилийн **дарамттай, хурдан хэмнэлт амьдралынхаа** дараа Жэни өндөр цалинтай хотын ажлаа өгөөд хөдөөгийн жижигхэн тосгонд шинэ амьдрал эхлүүлэв. Хэдийгээр тэрээр **ажил хэргийн өрсөлдөөнөөс** холдохдоо дуртай байсан ч хөдөө ирээд тун **тухгүй, уснаас гаргасан загас шиг** л байжээ. Одоо тэр хотдоо буцаад ирсэн бөгөөд өөрийн туршлагаасаа нэлээд ухаажсан байна.

*Тэр эмэгтэй **ажил хэргийн өрсөлдөөнөөс** холдохдоо дуртай байлаа.*

## Багийнхан амжилтандаа баярлацгаав



After a difficult start to the competition, when England did well to **keep their heads above water** in the match against the very strong Brazilian team (result: 1-1 ), the England team have been **on a roll**, winning every match including last night's spectacular game which ended in a 3-0 win. However, they can't afford to **put their feet up** because the next match will be the hardest yet.


- **keep your head above water**  
тэсч үлдэх
- **on a roll**  
дараалсан ялалтдаа баярлах
- **put your feet up**  
амрах

Тэмцээний эхний тоглолт Бразилийн хүчтэй багийн эсрэг байсан бөгөөд үүнд Английн баг сайн байж, **тэсч үлдэж** чадсан юм (дүн : 1-1 –р тэнцсэн). Тэд дараа дараагийн тоглолтууддаа ч ялалт байгуулж, урьд шөнийн тоглолтонд гэхэд л 3-0 –р ялан, **үүндээ баярлаж байлаа**. Гэвч тэдэнд **амрах** боломж олдсонгүй, учир нь дараагийн тоглолт илүү хэцүү байлаа.

*Англичууд хэтэрхий эрт амарснаас алдаа гаргав.*

# *Харилцан яриа*

## Киноны хэсгээс



*Hugh Grant realises he has **put his foot in it**.*

In the film *Four Weddings and a Funeral*, Hugh Grant meets an old friend, and asks him, 'How are you, and how's your girlfriend?' The man replies, 'She's not my girlfriend any more.' 'That's good,' says Grant, 'you probably didn't know, but she was **two-timing** you with someone else.'

The man looks deeply shocked and says, 'She's my wife now.' Hugh Grant realises he has **put his foot in it**, and he **kicks himself** for being so stupid.

- **two-timing**  
хуурах, үнэнч бус
- **put your foot in it**  
санамсаргүйгээр хэн нэгнийг уурлуулах
- **kick yourself**  
өөртөө уур хүрэх

*Дөрвөн хурим нэг оршуулга* кинон дээр Хью Грант хуучин найзтайгаа уулзаад “Сайн уу, найз охин чинь сайн уу?” гэж асуутал цаадах нь “Тэр одоо миний найз охин байхаа больсон” гэтэл Грант “Сайн юм болж, чи магадгүй мэдэхгүй байх, гэхдээ цаадах чинь чамд **үнэнч бус** байсан юм.” гэлээ. Гэтэл нөгөө залуу гайхаж цорирдсон харцаар “Одоо тэр миний эхнэр болсон шүү дээ” гэв. Хью Грант харин **санамсаргүйгээр түүнийг уурлуулсанаа** ойлгоод, тэнэг байдалд орсондоо **өөртөө уур хүрэв**.

〔 Хью Грант  
санамсаргүйгээр түүнийг  
уурлуулсанаа ойлгов. 〕

## Чи нууц хадгалж чадах уу?



*Don't let the cat out of the bag.*

A friend has just told you a secret. Then someone asks, 'What were you two talking about?'

Do you ...

- (a) smile and just say mysteriously, '**That would be telling**'? or
- (b) **spill the beans**?

Your friends are planning a surprise party for someone.

Do you ...

- (a) keep your mouth shut until the party? or
- (b) **let the cat out of the bag** the day before?

- **That would be telling.**  
энэ бол нууц
- **spill the beans**  
нууц илчлэх
- **let the cat out of the bag**  
нууцаа түрүүлж задлах, хэлэх

Найз чинь чамд нэгэн нууц хэлэв. Тэгтэл хэн нэг нь чамаас “Та хоёр сая юу яриад байв?” гэж асуужээ.

Тэгвэл та яах вэ?

- (a) инээгээд, “**энэ бол нууц**” гэж хэлнэ  
(b) **нууцаа илчилнэ**

Найзууд чинь хэн нэгэнд зориулж гэнэтийн бэлэг болгохоор үдэшлэг бэлджээ.

Тэгвэл та ...

- (a) үдэшлэг болтол амаа тас хамхина  
(b) нэг хоногийн өмнө **нууцаа түрүүлж задлана**

**Нууцаа битгий эрт  
задлачихаарай.**



## Санал бодол



Is B agreeing or disagreeing?

A: He talks too much.

B: **You're telling me!** I sat next to him on the bus yesterday!

A: It's hot today, isn't it?

B: **You can say that again.**

A: He's an intelligent boy; the real problem is that he's lazy.

B: I think you've **hit the nail on the head.**

- **You're telling me.**  
би үүнийг мэднэ
- **You can say that again.**  
би үнэхээр санал нэг байна
- **hit the nail on the head**  
сайн тайлбарлаж хэлж өгөх

В хүн зөвшөөрч байна уу, татгалзаж байна уу?

А: Тэр хүн хэтэрхий их ярих юм.

В: Харин тийм, **би үүнийг мэднэ**. Өчигдөр автобусанд би түүний хажууд суусан юм.

А: Өнөөдөр ч халуун байна шүү, тийм байгаа биз?

В: **Би үнэхээр санал нэг байна.**

А: Тэр бол үнэхээр ухаантай хүү, ганц гэм нь залхуу.

В: Миний бодлоор чи нэг **сайн тайлбарлаж хэлж өгөх** нь зүйтэй байх.

## Надад итгэ л дээ!



*I'm not pulling  
your leg!*

SAM: Hello?

TOM: Sam! Help me!

SAM: What's the matter, Tom?

TOM: I'm hanging from this rock by one hand. I can't hold on much longer.  
Call the rescue service quickly!

SAM: Very funny, Tom. Why are you always **pulling my leg**?

TOM: Sam! I'm not **having you on**. It's true! Honestly!

SAM: **Pull the other one**, Tom!

- **pull someone's leg**  
ТОГЛОХ, даажигнах
- **have someone on**  
худлаа хэлэх (тоглоом шоглоомоор)
- **pull the other one**  
би чамд итгэхгүй байна

Сээм: Байна уу?

Тоом: Сээм, надад туслаарай!

Сээм: Юу болоо вэ, Тоом?

Тоом: Би нэг гараараа чулуунаас зүүгдчихээд байна. Удаан тэсэхгүйнээ.

Аврах багийг яаралтай дуудаад өгөөч!


Сээм: Үнэхээр хөгжилтэй байна, Тоом. Чи яахаараа үргэлж хүнээр даажигнаж байдаг юм?

Тоом: Сээм, би худлаа хэлээгүй ээ. Энэ үнэхээр үнээн!

Сээм: Би чамд итгэхгүй байна, Тоом!

*Би чамаар  
тоглоогүй ээ.*

## ЧИХЭЭ ТҮЛЭВ



*It was uncomfortable,  
to say the least.*

Have you heard this joke?

A: My ears got burnt!

B: How?

A: I was ironing when the phone rang. Instead of picking up the phone I picked up the iron.

B: That must've hurt!

A: **To say the least.**

B: Let's **get this straight**: you said you burnt both ears. Right?

A: Yes.

B: How **on Earth** did you burn the other ear?

A: The person called again.

- **to say the least**  
маш их
- **get it straight**  
тодорхой болох
- **on Earth**  
би төсөөлж чадахгүй нь

Та ийм онигоо урьд нь сонсож байсан уу?

А: Би чихээ түлчихлээ!

В: Яаж тэр вэ?

А: Би юм индүүэж байтал утас дуугараад. Тэгээд утасны оронд индүүгээ чихэндээ наачихлаа.

В: Айхтар өвдсөн байх даа!

А: **Маш их.**

В: Жаахан тодорхой болгоцгооё, чи түрүүнд хоёр чихээ хоюуланг нь түлчихлээ гэсэн, тийм байхаа?

А: Тийм ээ.

В: Харин нөгөө чихээ яаж түлснийг чинь би **төсөөлж чадахгүй нь?**

А: Нөгөө хүн чинь дахиад залгасан юмаа.

*Энэ үнэхээр эвгүй байсан шүү, маш их өвдсөн.*

# *Бодох, сурах*

# Таамаглал



*I thought you said he  
was a **safe bet**.*

Who is most optimistic? Who is most pessimistic?

CHRIS: I think we might get a good pay rise this year.

SAM: **That'll be the day!**

TOM: I think it's **on the cards**.

HELEN: I think it's a **safe bet**. The company's made a big profit this year.

KATE: You're right, but it's still **touch and go** whether they'll share it with us.



- **that'll be the day**  
тэгвэл ч гэнэтийн зүйл болно доо
- **on the cards**  
магадгүй
- **safe bet**  
бараг гарцаагүй
- **touch and go**  
итгэлгүй, эргэлзээтэй

Хэн нь өөдрөг, хэн нь гуртанги байна?

Крис: Энэ жил ч бидний цалин гайгүй өсөх байх гэж би бодож байна.

Сээм: **Тэгвэл ч гэнэтийн зүйл болно доо!**

Тоом: Миний бодлоор тэгж **магадгүй**.

Хелен: Минийхээр бол энэ бол **бараг л гарцаагүй**. Компани маань энэ жил ихээхэн орлого олсон биз дээ.

Кэйт: Та нарын зөв өө, гэхдээ тэд орлогоо бидэнтэй хуваалцана гэхэд **эргэлзээтэй** л юм шүү.

*Чи түүнийг бараг гарцаагүй түрүүлнэ гэж хэлсэн биш үү?*

## Ой ТОГТООЛТ



*He suddenly realised that the speaker's name had slipped his mind.*

A woman was having dinner with a friend and her husband, when she noticed that her friend always called her husband loving names like *Honey*, *Darling*, *Sweetheart* etc. While her husband was out of the room, the woman said, 'It's 70 Years since you two **tied the knot** but you still call him those pet names. That's wonderful. It must **take some doing** to keep romance alive for so long.' Her friend answered, the truth is that his name **slipped my mind** about ten years ago.'

- **tie the knot**  
гэрлэсэн
- **take some doing**  
амаргүй
- **slip your mind**  
мартах

Найз нь нөхрөө дандаа Хонгор минь, Амраг минь, Хайрт минь гэж дууддагаа хэлж байх үед тэр хүүхэн найзтайгаа, түүний нөхөртэй нь оройн зоог барьж байлаа. Нөхөр нь өрөөнөөс гараад явсан хойгуур өнөө хүүхэн “Та хоёр **гэрлээд** 70 жил өнгөрч байхад чи нөхрөө ингэж энхрийлж дуудаж байдаг. Үнэхээр гайхалтай юм. Ийм удаан хугацаанд ингэж романтик байх ч **амаргүй** хэрэг байх даа” гэхэд найз нь “Яг үнэндээ бол 10 жилийн өмнөөс л би түүний нэрийг **мартаж** орхисон юм” гэж хариулжээ.

*Тэр гэнэт илтгээчийн  
нэрийг мартчихсанаа  
мэдлээ.*

## Зөв ба буруу дуудлага



*Boris thought he was getting the hang of the language until he tried ordering a cup of coffee.*

A **golden rule** of pronunciation is: use word stress correctly.

You probably know that one part of a word is 'stressed' (= stronger than the other parts), for example: PHOtograph, phoTOgrapher, photoGRAPhic.

Listen for the stress in words. Then you'll **get the hang of** word stress and be able to use it more. If you can do this, your pronunciation will improve **just like that**.

- **golden rule**  
чухал дүрэм, алтан дүрэм
- **get the hang of**  
юмыг яаж хийх/хэрэглэхийг сурах
- **just like that**  
хурдан, амархан

Зөв дуудах **алтан дүрэм** бол үгийн өргөтгөлийг хэрэглэх явдал юм.

Үгийн нэг хэсэг нь өргөтгөлтэй байдгийг чи магадгүй мэдэх байх (= бусдаасаа илүү тод дуудагддагийг) . Жишээ нь : PHOtograph, phoTOgrapher, photoGRAPhic гэх мэт.

Үгэн дэх тод дуудагдах хэсгийг анхаарч сонсч бай. Тэгвэл чи үгийн өргөтгөл гэдгийг ойлгож, яаж хэрэглэхийг нь **сурна**. Хэрэв чи ингэж чадвал чиний дуудлага их **амархан** сайжрах болно.

*Борис, нэг аяга кофе захиалах гэж ядах хүртлээ өөрийгөө хэл сурчихсан гэж бодож явжээ.*

## Хөгжим сонсов



*I can't make head  
nor tail of it.*

Learners of English sometimes say, 'I don't listen to English on the radio because it's too fast and I can't **make head nor tail of it.**'

